

2019 оны I улирлын эдийн засгийн тойм

I. Эдийн засгийн өсөлт

2019 оны I улирлын эдийн засгийн өсөлт 8,6% гарав. Нийт эрэлтийн талаас энэхүү өсөлтөнд өрхийн эцсийн хэрэглээний зардал 2,7%, үндсэн хөрөнгийн хуримтлал буюу бүрдэлт 11,8%, цэвэр экспорт – 6,6%, түүний дотор экспорт – 25,2%, импорт 31,8% тус тус хувь нэмрээ оруулсан байна. (2018 онд экспорт – 11,8%, импорт 17,2% байв). Өмнөх оноос ялгаатай нь үндсэн хөрөнгийн бүрдэлтийн хувь нэмэр огцом нэмэгдсэн, өрхийн эцсийн хэрэглээний зардлын өсөлтөнд оруулсан хувь нэмэр 2018 оны улирлуудад байгаагүй хэмжээнд нэмэгдсэн байна. Улирлын нөлөөллийг арилгаж тооцсон ДНБ өсөлт 6,2% байгаа нь өмнөх оны улирлуудад гарсан жилийн өсөлтөөс их байна. ДНБ-ий дефлятор (6,4%) өмнөх оны эхний хагас жил, жилийн дүнтэй ижилхэн, өрхийн эцсийн хэрэглээний зардлын дефляторын өсөлт хэрэглээний үнийн индексээр тооцсоноос бага, өмнөх оны эхний хагас жилийнхээс их байна. Материаллаг эргэлтийн хөрөнгө (inventory), үнэт зүйлсийн өөрчлөлтийн хувьд эхний улиралд абсолют хэмжээний өөрчлөлт, өсөлтөнд оруулсан хувь нэмэр аль алин нь өмнөх жилээс эрс бага (0,3%) байгаа нь өмнөх оны эцсээс хөрөнгө оруулалт, эдийн засгийн идэвхижил нэмэгдсэнтэй холбоотойгоор тайлбарлаж болно. Гадаад секторын хувьд экспортын дефлятор 4,5%, импортынх 6,4% өссөнөөр худалдааны нөхцлийн индекс 104,5% болсон байна. Гэхдээ энэ нь өмнөх жилийн эхний хагастай харьцуулахад буурч буй хандлагатай байна. Эдийн засгийн нийт нийлүүлэлтийн хувьд авч үзвэл 2019 оны эхний улирлын өсөлтөнд аж үйлдвэр, барилгын секторын оруулсан хувь нэмэр нэмэгдэж (3,8%) өмнөх оны улирлуудаас эрс өссөн байна. Үйлчилгээний секторын хувь нэмэр 3,9% болсон нь мөн өмнөх оны улирлуудаас нэмэгдсэн дүр зургийг харуулж байна. Өсөлтөнд оруулсан бүтээгдэхүүний цэвэр татварын хувь нэмэр өмнөх оны улирлуудынхаас багасаж 0,8% болсон нь секторуудын идэвхижил бүтээгдэхүүний цэвэр татваргүйгээр нэмэгдэж өсөлтөнд оруулсан хувь нэмэр нь өссөнийг харуулж байна. Гэхдээ эдийн засгийн секторуудын үнийн дефляторуудын өсөлт нь бодит үйлдвэрлэлийн өсөлтөөс илүү, ялангуяа үйлчилгээний секторын дефляторын өсөлт эрс нэмэгдсэн нь нийт эдийн засагт

инфляцийн дарамт нэмэгдсэнийг харуулж байна. Цаашдаа эдийн засгийн өсөлтөнд тогтвортой чанар (sustainability), хүртээмжтэй чанар (inclusiveness) хоёрыг онцгой анхаарах, бизнес, хөрөнгө оруулалтын орчины реформ хийх (зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулах, хөрөнгө оруулалтын орчины тогтвортой байдал гэх мэт) асуудал 2019-2020 оны гол, хойшлуулшгүй зорилт юм.

II. Үнэ, инфляц

1. Хэрэглээний үнийн индекс 2019 оны эхний улиралд бүх бүс нутгаар өсөлттэй байна. Ингэхдээ хүнсний үнийн инфляц Улаанбаатараас бусад бүсийн хувьд ерөнхий индексээсээ илүү байгаа нь хүнсний хэрэглээний гол зүйл болох махны үнийн өсөлттэй голчлон холбоотой байна.


Хүснэгт 1. 2019 оны I улирлын инфляц эдийн засгийн бүсүүдээр (%)

		Баруун бүс		Хангайн бүс		Төвийн бүс		Зүүн бүс		Улаанбаатар хот	
		2019/4	2019/4	2019/4	2019/4	2019/4	2019/4	2019/4	2019/4	2019/4	2019/4
		2017/4	2018/4	2017/4	2018/4	2017/4	2018/4	2017/4	2018/4	2017/4	2018/4
1	Хэрэглээний үнийн индекс	-	105,8	-	106,4	-	105,4	-	107,3	-	107,8
2	Хүнсний үнийн индекс	-	110,2	-	109,0	-	109,2	-	112,0	-	107,3
3	Хонины мах (кг)	32,2	22,4	25,2	28,1	26,1	29,3	42,2	23,5	23,0	19,5
4	Үхрийн мах (кг)	35,7	29,3	31,7	34,2	20,6	35,6	36,5	22,5	20,7	15,3
Мемо:											
5	Долларын нэрлэсэн ханш									108,8	110,0
6	Долларын бодит ханш									-	102,8

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк, Зохиогчийн тооцоо


Зураг 1-т малын үнийн өөрчлөлт, бүс нутгаар, Зураг 2-т малын гаралтай түүхий эдийн үнийн бүс нутгийн өөрчлөлт, Зураг 3-т хонь, үхрийн махны 1 кг-ын бүсийн дундаж үнийг үзүүлэв.

Зураг 1. Малын үнийн өөрчлөлт, бүс нутгаар




Эх сурвалж: ҮСХ, зохиогчийн тооцоо

Зураг 2. Малын гаралтай түүхий эдийн үнийн өөрчлөлт, бүс нутгаар



Эх сурвалж: ҮСХ, зохиогчийн тооцоо

Зураг 3. Махны үнэ, бүс нутгаар



Эх сурвалж: ҮСХ, зохиогчийн тооцоо

Дээрх хүснэгтээс харахад:

- Хүнсний үнийн индекс Улаанбаатар хотоос бусад бүсэд хэрэглээний үнийхээс илүү өсөлттэй байна.
- 1кг хонины махны үнэ бүс бүсийн хэмжээнд 19,5-28,1% өссөн бөгөөд хамгийн их өсөлт Хангайн бүсэд, хамгийн бага өсөлт Улаанбаатар хотод байна.
- Долларын нэрлэсэн ба бодит ханшийн өсөлтийн зөрүү 7,8% буюу бодит өсөлт нь 2,8%, сар бүрийн хэлбэлзэл нь огцом өөрчлөлтгүй жигд байгаа нь “муу л бол зүүн хойд талын овоохой” болдог ханшийн инфляцид шилжих үр нөлөө бага буйг харуулж байна.

Инфляцийн өсөлтийн хүчин зүйлүүдийн задаргааг энд авч үзэлгүйгээр зөвхөн махны үнийн өсөлтийн шалтгааныг тодруулах нь зүйтэй бөгөөд учир нь махны үнийн өсөлтийн өрхийн төсөвт үзүүлэх дарамт нэмэгдсэн, энэхүү дарамтыг багасгахын тулд төр, засгаас авч хэрэгжүүлж буй болон авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдийн үндэслэлийг сайн гаргах нь чухал юм. Юуны өмнө жил бүрийн 4,5-р сард тохиолддог улирлын хэлбэлзлийг анхаарах нь ойлгомжтой. Олон жилийн дунджаар жил бүрийн өдийд инфляцийн геометрийн дундаж болон медиан өсөлт түүхэн байдлаараа бусад саруудаас

өндөр байдгийг тэмдэглэвэл зохино. (4-р сард геометрийн түүхэн дундаж нь 2,3%, түүхэн медиан нь 1,8%, 5-р сард 1,7%, 1,1%). Гэхдээ энэ нь махны үнэ жилийн энэ үед өсдөг дараа нь тогтворждог гэсэн хэвшмэл сэтгэлгээ, эсвэл зах зээлийн үнийг буулгах, үнийн өсөлтөнд ченжүүд гэх мэт буруутай гэж үздэг, тагнуулынхан хүртэл оролцож шалгадаг төрийн оролцооны паник сэтгэлгээний алинаар ч бүрэн тайлбарлагдахгүй, илүү гүнзгий, нийгэм – эдийн засгийн гэж болохоор шалтгаантай гэдгийг одооноос бодлогын түвшинд анхаарах нь чухал юм.

2. Махны үнийн өсөлтийг эдийн засгийн талаас нь тайлбарлахын тулд малын үнэ, малын түүхий эдийн үнэ, зах зээлийн бүтэц, хандлагыг анхаарах, нийгмийн талаас нь тайлбарлахын тулд малчин өрхүүдийн бүтэц, мал-хөрөнгийн бүтцийн өөрчлөлт, орлого, хэрэглээний тал дээр өрнөж буй үйл явц, хөдөөгийн ядуурал, орлого, хөрөнгийн тэгш бус байдлын үйл явц хэрхэн өөрчлөгдөж буйг иж бүрэн, өргөн хүрээтэйгээр судлах нь зайлшгүй болсон байна.
3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний бүсийн дундаж үнийн сүүлийн 4 жилийн эхний улирлуудын хандлага, олон жилийн дунджаас харахад зах зээлийн нэг ерөнхий зүй тогтол ажиглагддаг бөгөөд энэ нь малын үнийн өсөлт, бууралт, малын түүхий эдийн үнийн өсөлт, бууралт, зах зээлийн байдал хоорондоо урвуу хамааралтай, өөрөөр хэлбэл, малын үнэ төрлөөрөө өссөн үед малын түүхий эдийн үнэ буурдаг *vice versa* байдал юм.

Цаашид инфляцийн хүлээлтийг удирдах зорилгоор бүс нутгийн инфляцийн судалгааг гол бараа, түүхий эд, хэрэглэгчдийн бүлгээр ялгавартайгаар хийх, мөнгөний бодлогын үр нөлөө бүс нутгуудад хэрхэн тархаж буй талаар анхаарах нь зүйтэй. Энэ нь мэдээж зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төдийгүй нийгэм-эдийн засгийн бусад хүчин зүйлүүдээр тайлбарлагдахаар байгаа бөгөөд цаашид гүнзгийрүүлж судлах, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төрийн бодлогын үр нөлөө төдийгүй малчин өрхүүдийн behavioral шинж талаас нь анхаарвал зохих юм.

4. Махны үнэ бүрдэлтийн нийлүүлэлтийн хэлхээний бүрдэл хэсэг бүр дээр үнийн өсөлтийг “эрэн сурвалжилж”, “буруутныг илрүүлж сүр дуулиантайгаар зарладаг” хандлага үндсээрээ буруу бөгөөд өмнө

дурьдсан ёсоор малчин өрхүүдийн дунд сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж буй нийгэм-эдийн засгийн үйл явц, түүний хандлагыг тодорхойлох нь малын, махны үнэ яагаад өсдөг вэ гэдгийг тодорхойлоход ч хэрэгтэй юм. Сүүлийн арваад жил малчин өрхүүдийн дунд хөрөнгийн ялгарал буюу малын тоо, сүргийн бүтэц, чанар гэх мэтээс үүдсэн орлого, хэрэглээний томоохон өөрчлөлт явагдсаны үр дүнд өнөөгийн байдлаар нийт малын олонхи (80% орчим) нь нийт малтай өрхийн цөөнхөд (45% орчим) харъяалагдах болсноор махны зах зээлийн нийлүүлэлтийн талд өөрсдийн мал, махаа зарах хэрэгцээ гэхээсээ илүү зах зээлийн эрэлтийг дагасан, сонжсон, хүлээсэн, үнийн, зах зээлийн мэдээллийн асиметрик байдлаас гарсан, илүү “entrepreneur” шинжтэй болсон малчин өрхүүд махны зах зээлийн нийлүүлэлтийг голчлон хангаж байгаа. Эдгээр нийлүүлэгчийн хувьд Улаанбаатар хотын хэрэглэгчид хямд үнэтэй мах идээсэй гэхгүй нь ойлгомжтой.

III. Мөнгө

Мөнгөний эдийн засгийн (monetary economics) хувьд ерөнхийдөө бодит эдийн засгийн тусгал, илэрхийлэл болдог ч дотроо маш нарийн нийлмэл үйл явц явагддаг тул энд тэр бүх нарийн ширийнийг бичих боломжгүй. Гэхдээ M2-ын өсөлтийг дурьдах төдий хязгаарлалгүйгээр ерөнхий хандлагыг авч үзье.

1. Нийт мөнгө буюу M2-ын өсөлт 2019 оны эхний улирлын байдлаар 22,6% өссөн нь мөнгөний нийлүүлэлт сөрөг өсөлттэй байсан 2015 оныг даван туулж 2016-2018 онд эерэг өсөлттэй болсон хандлагын үргэлжлэл болж байна. Гэхдээ 2019 оны эхний улиралд нөөц мөнгөний өсөлт илүү хурдацтай өссөнөөр мөнгөний үржүүлэгчийн хурдац буурсаныг анхаарах нь зүйтэй.
2. Нийт хадгаламжийн өсөлт 2016-2018 оны 3 жилийн хандлагаас өөр болж M2-ын өсөлтөөс түрүүлсэн нь нэг талаас иргэдийн банкны системд үзүүлэх итгэл нэмэгдэж буйн илэрхийлэл, нөгөө талаас эдийн засгийн зээлжүүлэлтийн тал дээр анхаарах шаардлагатайг харуулж байна. Эдийн засгийн мөнгөжилтийн үйл явц нэмэгдэх хандлага хадгалагдаж буй хэдий ч нийт мөнгөний өсөлтийн хурдац нийт хадгаламжийнхаас доогуур, дотоод цэвэр зээлийн өсөлт түүнээс мөн бага байна.

3. Хэдийгээр онол-арга зүйн хувьд маргаантай байдаг ч мөнгөний тооны онолын гол үндэслэл болдог мөнгөний эргэцийг нэрлэсэн ДНБ ба нийт мөнгөний харьцаагаар тодорхойлдог бөгөөд энэ харьцаа 2016 оны I улиралд – 0,47, 2017оны I урилралд – 0,45, 2018 I – 0,40, 2019 оны I улиралд 0,38 болж байнга буурсан буюу мөнгөний эргэц удааширч ирсэн байна.
4. 2019 оны I-р улиралд төгрөгийн хадгаламжийн өсөлт валютынхаас илүү болсон ч валютын ханшийн сулралаас валютын хадгаламжийн өсөлт илүү хурдацтай байгаа нь санхүүгийн долларжилтийн үйл явц хангалттай түвшинд саарахгүй байгааг илтгэж байна.
5. Гадаад цэвэр активын өсөлт огцом нэмэгдэж (168%), валютын нөөц нэмэгдэж байгаа нь сайн боловч дотоод цэвэр зээлийн өсөлт аядуу, нөөц мөнгөний өсөлт өндөр байгаа нь банкны системийн хэмжээнд гүйлгэн чадварын (liquidity) илүүдэл үүссэн байж болзошгүй дохио юм. Мөнгөний бодлогын хүрээнд гүйлгэн чадварын илүүдэл (дутагдал)-ийн талаар бодлогын тусгайлсан судалгаа шаардлагатай тул энд хөндөөд л орхив.
6. Төв банк, арилжааны банкуудын нэгдсэн тэнцэл, тэдгээрийн өөрчлөлт нь мөнгөний бодлого, төсөв, мөнгөний бодлогын уялдаа, эдийн засгийн өсөлтийн бодлогын нэгдмэл хандлага, судалгаа шаарддаг нарийн нийлмэл үйл явц бөгөөд 2019 оны I улирлын байдлаар төв банкны болон арилжааны банкуудын нэгдсэн тэнцэл 25,9% өргөжиж энэхүү өргөжилтийн 5,5%-ийг M1 мөнгө, 16,9%-ийг нийт депозит буюу M2 мөнгө 22,4%-ийг хангасан байна.
7. Валютын ханшийн үйлчилж буй дэглэм эрх зүй, институцийн хувьд зүгширч буй хэдий ч “fear of floating” - “хөвөхөөс болгоомжлох айдас” хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид, олон нийтийн дунд түгээмэл байгаагаас ханшийн зах зээлийн хөгжилд сөрөг үр нөлөө үзүүлж зайлшгүй шаардлагатай үед л интервенц хийх бодлогын сонголтонд дарамт үзүүлж байна.
8. Хөгжилтэй улсууд, зүгшрэн хөгжиж буй болон хөгжиж буй улсуудын төв банкуудын мөнгөний бодлогын нийтлэг хандлага болж буй “мөнгөний бодлогын хэвийн байдлыг сэргээх” (normalization of monetary policy) хандлага сүүлийн 3 жилд Монгол улсын төв банкны бодлого, үйл ажиллагаанд хэрэгжснээр мөнгөний бодлого хэвийн голидролдоо эргэн орсон байна. Үүнийг Монголбанк,

арилжааны банкуудын нэгдсэн тэнцлүүд болон мөнгөний, бодит эдийн засгийн үзүүлэлтүүд илтгэж байна.



IV. Төсөв

2019 оны 1-4 сарын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 286,5 тэрбум төгрөг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 3,9% болов. 2018 оны мөн үед энэ нь -33,6 тэрбум, -0,5 байв. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зөрүүг (±) санхүүжүүлэх “шугамын дээгүүрх” үндсэн 4 эх үүсвэр нь

- a. Засгийн газрын харилцах, хадгаламжийн цэвэр өөрчлөлт
- b. Засгийн газрын бонд
- c. Засгийн газрын зээл
- d. Засгийн газрын хөрөнгө оруулалт юм.

Өнгөрсөн 13 жилийн хугацаанд (2006-2018 он) төсвийн тэнцэл ердөө 4 удаа (2006, 2007, 2010, 2018 онуудад) эерэг тэнцэлтэй гарч байв. Санхүүжилтийн нэг






















гол эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн цэвэр зөрүүний хувьд авч үзвэл төв банк, арилжааны банкуудын тэнцэлд тусгагддаг засгийн газрын олгосон зээл (авлага), засгийн газрын хадгаламж (өглөг) хоёрын зөрүү буюу засгийн газрын цэвэр авлага нийт дүнгээрээ 10 удаа сөрөг тэмдэгтэй буюу төв банк, арилжааны банкуудаас авах цэвэр авлагатай, 3 удаа эерэг тэмдэгтэй буюу өглөгтэй явж ирсэн байна. Төсвийн орчил дагасан, тэлсэн бодлоготой жилүүдэд, тухайлбал, 2011-2016 онд төсвийн алдагдал эрс нэмэгдэж санхүүжилтийн эх үүсвэр нь засгийн газрын бонд голчилж байсан бөгөөд эдгээр онд засгийн газрын цэвэр авлага 2013 он дуустал ихээхэн нэмэгдэж байсан бол 2014-2016 онд засгийн газрын цэвэр өглөг эрс нэмэгдсэн, 2017 оноос энэ хандлага өөрчлөгдөж цэвэр авлага 2018 онд 1330,8 тэрбум төгрөг болжээ. 2019 оны эхний улирлын байдлаар засгийн газрын цэвэр авлага -1756,5 тэрбум төгрөг үүнээс төв банкнаас авах цэвэр авлага -1067,4 тэрбум, арилжааны банкууд -689,1 тэрбум төгрөг байна. Эдгээр болон бусад тоог ашиглан төсвийн зардлыг

- a. мөнгө бүтээх түүний дотор мөнгө хэвлэх замаар
- b. гадаад валютын нөөцөөс
- c. гадаад зээл
- d. дотоод зээл ашиглан санхүүжүүлдэг сонгодог хэлбэрүүд манайд ямархуу байдлаар хэрэгжиж байсныг болон “өрийн мөнгөжүүлэлт”-ийн үр нөлөө ямар түвшинд байсныг цаашид судлах шаардлагатай.

Эндээс харахад төсвийн тэнцлийн асуудал бол зөвхөн төсвийн бодлогын хүрээгээр хязгаарлагдахгүй мөнгөний бодлого, түүний дотор төв банк, арилжааны банкуудын тэнцэл, нөөц мөнгөний хэмжээ, тэдгээрийн удирдлага, засгийн газар ба төв банкны үнэт цаас, гадаад валютын нөөц зэрэгтэй нягт холбоотой юм. Тиймээс төсөв, мөнгөний бодлогын уялдааг энэ хандлага дээр суурилан зохицуулалт хийж байх шаардлагатай.

V. Өрхийн эдийн засаг

2018 оны эцсээр Монголбанкны дэргэдэх Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн хот, хөдөөгийн 3050 гаруй өрхийн дунд түүвэр судалгаа явуулсан бөгөөд судалгааны зорилго нь өрхийн орлого, зарлага, төсвийн байдлыг дундаж өрхийн хувьд тодорхойлох, Монголын нийгмийн страта бүтцийн эдийн засгийн судалгааг эхлүүлэхэд оршиж байв. Судалгааны урьдчилсан үр дүнгээр анх удаа дундаж өрхийн тэнцлийг гаргаж мөнгөний бодлогын төдийгүй төсөв, макро эдийн засгийн бодлогын хэрэгцээнд ашиглах зорилгоор 2019 оны 5 сард Үндсэний статистикийн хороо, тус хүрээлэн хамтран “Өрхийн эдийн засаг-2019” нэртэй хурал зохион байгуулж цаашдын хамтарсан судалгаа, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон нь өрхийн эдийн засгийг тусгайлсан, бие даасан судалгааны объект болгох эхлэлийг тавьснаараа чухал ач холбогдолтой юм. Хүснэгт 4-т өмнө дурьдсан дундаж өрхийн тэнцлийг харуулав.

I. ХӨРӨНГӨ		47,226,390 ₮	II. ЗЭЭЛ		14,336,000 ₮
БИЕТ ХӨРӨНГӨ		45,574,457 ₮		Цалингийн зээл	4,940,200 ₮
	Орон сууц	34,037,480 ₮		Бизнесийн зээл	1,005,190 ₮
	Газар	4,801,060 ₮		Тэтгэврийн зээл	352,560 ₮
	Бусад ҮХХ	1,580,070 ₮		Хэрэглээний зээл	294,730 ₮
	Мал	210,060 ₮		Малчны зээл	116,530 ₮
	Тээврийн хэрэгсэл	4,406,610 ₮		Автомашинны зээл	287,960 ₮
	Үнэт эдлэл	362,240 ₮		Кредит картны зээл	107,280 ₮
	Бусад	176,940 ₮		Ипотекийн зээл	6,357,930 ₮
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ		1,651,930 ₮		Бусад	873,620 ₮
	Хадгаламж	1,402,580 ₮	ЦЭВЭР ХӨРӨНГӨ		
	Мөнгөн авлага	178,060 ₮	32,890,390 ₮		
	Хувьцаа	64,150 ₮		Нийт Хөрөнгө – Нийт Зээл	32,890,390 ₮
	Бусад	7,140 ₮			

Эх сурвалж: ЭЗССХүрээлэн

Өрхийн цэвэр баялаг (household net wealth) буюу актив, пассивын зөрүү 34 сая гарч байна. Цаашид энэ судалгааг уламжлал болгох, Үндэсний статистикийн хороотой хамтран нийгмийн тодорхой страта бүтцүүдийн дунд, тухайлбал, малчин өрхүүдийн тэнцэл, цэвэр баялаг зэргийг asset-хөрөнгө талаас нь мөнгөн үнэлгээнд шилжүүлж тооцох, өрхийн өр, өрийн үйлчилгээ, орлого, хадгаламж зэргийг нарийвчлан гаргах шаардлагатай.

Үндэсний статистикийн хорооны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар өрхийн сарын дундаж орлого, зарлага доорх байдалтай байна.

Хүснэгт 2. Өрхийн сарын дундаж орлого, зарлага

		2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019 I-III
1	Өрхийн сарын дндаж орлого	935,6	976,8	1132,3	1260,2
	<i>Хот</i>	<i>1007,7</i>	<i>1055,7</i>	<i>1237,2</i>	<i>1330,2</i>
	<i>Хөдөө</i>	<i>800,1</i>	<i>919,7</i>	<i>942,0</i>	<i>1130,1</i>
2	Өрхийн сарын дндаж зарлага	1051,1	1023,5	1160,1	1336,5
	<i>Хот</i>	<i>1120,3</i>	<i>1077,1</i>	<i>1216,2</i>	<i>1376,1</i>
	<i>Хөдөө</i>	<i>921,0</i>	<i>916,6</i>	<i>1058,4</i>	<i>1263,0</i>
3	Өрхийн сарын дндаж орлогын нэрлэсэн өсөлт, %	-101,9	4,4	15,9	11,3
4	Өрхийн сарын дндаж орлогын бодит өсөлт (2016 оны зэрэгцүүлсэн үнээр %)	-11,5	1,2	8,7	4,3

Эх сурвалж: ҮСХ

Өрхийн сарын дундаж орлогыг бүлэглэж үзвэл Улаанбаатар хотод 1,4 сая төгрөг, Төвийн болон Зүүн бүсэд 1,2 сая төгрөг, Баруун болон Хангайн бүсэд 1,1 сая төгрөг байна. 2019 оны I улиралд эдгээр нэрлэсэн орлогыг бүс бүрийн инфляциар засварлаж тооцвол Улаанбаатар хотод 1,3 сая, Төвийн болон Зүүн бүсэд 1,1 сая, Баруун болон Хангайн бүсэд 1,0 сая төгрөг, бүс бүрийн хүнсний үнийн индексээр зарлагын бүтцэд нь хүнсний зардлын эзэлж буй дунджаар тооцоолон үзэхэд эдгээр тоо нилээн багасахаар байна. Хүнсний бүтээгдэхүүний зарлага 300 мянган төгрөг хүртэл мөнгөн зарлагатай өрхийн хувьд 32,8%, 500-700 мянган төгрөг-31,3%, 700-900 мянга 28,1%, +900 мянга -19,7% байгаа нь үүнийг нотолж байна.

Монголбанк

2019 оны 5 сар